# Багшийн хөгжилд сургууль хамт олны гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх боломж

Илтгэгч нь: БЗД-ийн 53-р сургуулийн
Сургалтын менежер: Н.Наранцэцэг

# Түлхүүр үг:

- Багш хөгжих орчин
- Багшийн эрх зүйн орчин
- Багшийг материаллаг орчин
- Багшийн үйлийн орчин
- Багшийн дэмжлэг
- Багшийн урмашуулал
- Багшийн сэтгэл  санааны орчин
- Багшийн үр ашигтай хяналт
- Багшийн амьдралын хэмнэлтэт байдал
- Багшийн цаг ашиглалт, үр ашигтай зарцуулалт
- Багшийн хөгжилд сургууль, хамт олны нөлөөлөл, харилцан хамаарал, шүтэлцээ.

# *Асуудлын үндэслэл*

- Материаллаг орчин
- Эрх зүйн орчин
- Үйлийн орчин
- **Багш хөгжих орчин**

*Багш хөгжих орчин:*

Багш хөгжих орчин. Багшийг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр хөгжүүлэх, төлөвшүүлэхэд дараах орчинг бүрдүүлэх талаар сургууль хамт олон анхаарах нь зайлшгүй шаардагатай.

- Эрх зүйн орчин
- Материаллаг орчин
- Үйлийн орчин

# *Материаллаг сонирхол*

Багш хөгжих орчины бүрдэлд багш хөгжих сонирхол нь  тулгуур болох учиртай

- Дэмжлэг
- Сонирхол
- Урамшуулал

## *Сэтгэл санааны сонирхол*

- Идэвхтэй санаачлага
- Цагийн менежмент
- Амьдралын хэмнэлтэй байх

- Багш хөгжих сонирхол
  - Материаллаг сонирхол
  - Урамшуулал
  - Сэтгэл санааны сонирхол
  - Дэмжлэг

# Үр ашигтай хяналт

Ажиллагсдыг шаардлагатай мэдээллээр хангах мэдээ судалгаа, график, сургалт явуулах их дээд сургуулиудын мэдээлэл эрх зүйн баримт бичиг танилцуулах. Багшлах эрх, мэргэжлийн зэрэгт орох талаар танилцуулах

# Ирээдүйд чиглэсэн байх

- Багш хөгжих орчинг бүрдүүлээд, сонирхолыг нь төрүүлсэн явцад эдгээрийг зөв оновчтой зохицуулан зохион байгуулах сургуулийн үр ашигтай төлөвлөлт, үйл ажиллагааны зохистой хяналт шаардлагатай байдаг

# Дээрх ажиллагааны үр дүнд тухайн сургуулийн хичээлийн үүргийн нэгдэл хангагддаг байх учиртай

- Сургуулийн үйл ажиллагааны хяналт
  - Ирээдүйд чиглэсэн байх
  - Ажиллагсадыг шаардлагатай мэдээллээр хангах
  - Хосолсон аргуудыг хэрэглэдэг байх
  - Уян хатан байх

- Хичээлийн үүрэг
  - Хөгжүүлэх
  - Төлөвшүүлэх
  - Мэдлэгжүүлэх

Хичээлийн эдгээр 3 үүргүүдийн нэгдлийг хангахад хичээл сургалтын үйл ажиллагаа амьд, сонирхолтой оролцогчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн байх дидактикийн зарчмуудад суурилсан байх нь чухал.



Сонсох үедээ 20%тогтоодог.

Харах үедээ 30% тогтоодог

Сонсоод харсан үедээ 50 % тогттодог.

Сонсоод, хараад, ярьсан үедээ 70% тогтоодог.

Сонсоод, уншаад, яриад бас дадлага хийсэн үедээ 90% тогтоодог

# Тогтоон санах стратеги

- Тогтоон санах
  - Дахин боловсруулж давтах аргаар шинээр сурсан зүйлээ улам утга төгөлдөр болгох
- Цээжлэн тогтоох
  - Сурагч ой тоондоо орсон мэдээллийг БАЙГАА ЧИГЭЭР нь тогтоож хадгадах
- Дэлгэрэнгүй тогтоолт
  - Шинээр сурсан зүйлээ өмнөх мэдлэгтэйгээ холбож, тэдний хоорондын уялдаа холбоог нь тодруулах

# Дээрх судалгаанаас үндэслээд дараах төлөвлөлт урган гарч байна

Багш сурган хүмүүжүүлэгчдийг гафикт сургалт, сертификатын сургалт, модуль сургалт, өдрөөр суралцах, ажиллахын зэрэгцээ суралцах магистрын сургалтанд суралцах зэрэгт хэд хичнээн багш байгааг тодорхойлон гаргадаг. Үүнээс ажиллахын зэрэгцээ суралцах багш нарт илүү анхаарал тавьж ажиллаж байгаа талаар доорхи мэдээллийг хандуулъя.

# Сургуулийн багш нарын, судалгааг үндэслэн багшийн хөгжлийн ойрын болон хэтийн төлөвлөлтийн боловсруулах нь чухал



**БЗД-ийн бага ангийн багш нарын боловсролын зэрэг /2010 оны байдлаар/**



# 53-р сургуулийн бага ангийн багш нарын мэргэжлийн зэргийн байдал /2010он/



# Сургуулийн багшийн хөгжил хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө

| **Сургалтууд** | | **2009-2010** | **2010-2011** | **2011-2012** |
|---|---|---|---|---|
| Графикт сургалт | | 27 | 27 | 27 |
| Сертификат | | 9 | 5 | 8 |
| Их дээд сургууль | Модуль | 8 | 9 | 11 |
| | Бакалавр | 3 | 5 | 2 |
| Мэдээлэл харилцаа технологийн сургалт | | 3 | 18 | 7 |
| Англи хэл /анхан шат/ | | 27 | 27 | 27 |
| Англи хэл /дунд шат/ | | 4 | 6 | 7 |

# Багш нарын суралцах боломж бололцоог гаргаж судлах:

- Уг судалгааг гаргахад жил бүр авагддаг БДБ судалгаа, багш нарын анкет судалгаанд үндэслэн ЗАН-н багш нартай фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулж мэргэжил боловсролоо дээшлүүлэх бодол санаанд нь үндэслэж хичээлийн жилийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгах  ажиллагааг зохион байгуулж суралцах хэрэгцээ шаардлагыг тодорхойлно. Багш нарт дэмжлэг үзүүлэх боломж тодорхойлох. Нэгэнт судалгаа ярилцлагад  нийцүүлж суралцах багш нарт сэтгэлзүйн болон материаллаг дэмжлэгийг үзүүлэхдээ

***а/*** Ээлжийг- өөрийн нь хүсэлтээр боломжтой хэлбэрээр давуу эрхээр сонголт хийлгэж зохицуулалтыг хийж гүйцэтгэн хичээлийн хуваарыг хийнэ.

***б/*** Ээлжит хичээлээс бусад ямар нэгэн ажлыг сургууль боломжоороо зохицуулалт хийнэ.

***в/*** Хичээлийн бэлтгэлийг жил улирлаар хийлгэж ажиллахыг анхааралдаа авч ажиллана. Ангийн орчин нөхцөл ангийн дулаалга, цэвэрлэгээ гэрэлтүүлгийн аюулгүйн байдал хэрэгцээг хамтран ажилладаг ээлжийн багш нар сургуулийн аж ахуйн баг хариуцан шийдвэрлэдэг.

***г/*** Багш нарыг суралцахад сургуулийн канон, принтер, зөөврийн компютерээр хангах нөхцөл боломжийг эрж хайн асуудлыг зохих газарт хандан уламжлах асуудлыг шийдвэрлэх. УИХ-ын гишүүн Ц.Батбаярын хөрөнгө оруулалтын хүрээнд 15 зөөврийн компьютер, 12 принтер, БСШУЯ наас 15 зөөврийн компьютерыг хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэв.

***д/*** Өрх толгойлсон багшид нүүрс түлээний мөнгө ҮЭХ-с /хандивлах/зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллахын зэрэгцээ, бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлж багш нарыг мэдээлэх хамт олонд нь мэдээлэх урам өгөх амжилт хүсэх ажиллагааг зохион байгуулдаг.

# Багшийн хөгжилд сургууль хамт олны дэмжлэг.

- Суралцаж байгаа багш нар илүү мэдээлэлтэй, бусдад мэдээллээ түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй байхын хувьд манлайлллыг илүү шаарддаг. Сургалтын орчинд /кабинет/ сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдаж байгаа хэрэгцээ шаардлага ямар байвал дөхөмтэй байх талаар  тэднээс мэдээллийг шаарддаг анги кабинетдаа хийж бусдыг уриалан дуудахыг хүсдэг. Учир нь багшийн коллежийн багш нарын сургалтын хэрэглэгдэхүүний талаар өгч байгаа сургалт хийлгэж байгаа сургалтын хэрэглэгдэхүүн их үр өгөөжтэй  байгаагаас гадна суралцагсдын сургалтаар уламжлагдан зайны сургалтыг авч байх нь тухайн сургуулийн  нэг менежмент байх үүднээс энэ хичээлийн жил энэ сургуульд суралцаж байгаа 5 багш болон сургуулийнхаа бүтээлч багш нарын баг зохион байгуулж эцэг эхийн нэрэмжит сургалтын хэрэглэгдэхүүний бүтээлийн өдөр, үүнээс уламжилж БЗД-н ЕБС-н дунд “Сургалтын хэрэглэгдэхүүний бүтээлийн өдрийн зохион явуулж 18 сургууль 300 багш нарыг хамруулсан нэгдсэн үзэсгэлэнг зохион байгуулж

- Энэ ажиллагааг сургууль дээрээ зохион явуулснаар мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд зайны сургалт болсон төдийгүй багш нарын санаа бодлыг уралдуулсан бүтээлч ажил болсон. Уг ажиллагаанд орлцож 3-р байр эзэлсэн 88-р сургууль, тусгай байр эзэлсэн 53-р сургуулиуд “улсын хэмжээнд зарлагдсан Гурван- Эрдэнэ БДС, НБГ-н хамтарсан уралдаанд оролцож 3-р байр, шилдэг 20-д багтаж өргөмжлөл авсан нь дээрхи ажлын үр дүн гэж үзэж байгаа болно







Багш нар дүүргийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа уралдаан тэмцээнд амжилттай оролцох нь мэргэжил боловсролоо дээшүүлж байгаа нэг хэлбэр төдийгүй тус сургуулийн багш нарын бичсэн илтгэл, реферат нь дүүрэг болон НБГ-т уншигдаж хэлэлцэгдсэн . Үүнд багш С. Өнөрбилэгийн "6 настай суралцагчдын хэрэглэгдэхүүний асуудалд....", багш Б.Халиунхүүгийн "Сургуулийн хөгжилд багш, сурган хүмүүжүүлэгчдийн оролцоо" сэдэвт илтгэл нь дүүрэг болон НБГ-т уншигдаж хэлэлцэгдэв.

Багш нар хичээлийн бэлтгэл хийж гүйцэтгэх, илтгэл, реферат бичиж боловсруулах, мэдээлэл авах, боловсруулахад тэдэнд компьютер, принтер, канон зайлшгүй хэрэгцээтэй байдаг. Үүнээс үндэслэн доорх судалгааг гаргахад

- Нийт багш нарын дунд суурин компьютеттай 34, зөөврийн компьютертай 11, принтертэй 17, интернеттэй 15 байгаа үүнээс суралцаж байгаа багш нарт суралцах үедээ хэрэглэх зөөврийн компьютертай болгох асуудал урган гарч ирдэг. Үүнтэй холбоотой багш нарын дунд өгөгдсөн зөөврийн компьютер нь ажлын байрнаас хөндийрүүлэлгүй мэргэжил,  чадвараа дээшлүүлэх, МХТ-ыг сургалтандаа өргөнөөр хэрэглэх, мэдээ мэдээлэл авах, мэдээллээ боловсруулах өргөн боломжийг олгож байна.

Сургалтын орчин нөхцөл, хэрэгцээ шаардлагад нийцсэн кабинет байгуулах,  бусдын ажил байдалтай танилцах, харилцан туршлага судлах хамтран ажиллах нь багш нарт санаа өгдөг нэгийг харж нөгөөг тунгаан сэдэлжүүлдэг тул бусад багш, сургуулиудын ажилтай танилцах ажиллагааг 54, Улаанбаатар, Гурван-Эрдэнэ БС, 5, 24, 14, 23, 13, зэрэг сургуулиудад багш нар очиж туршлага судалсан.

Багш хөгжиж байх бас нэг орчин бол эцэг эх асран хамгаалагчид ижил төрлийн багш нарын дунд зохион байгуулсан олон хэлбэрийн ажлууд, сургалт  юм.




Насанд хүрэгчдийн дунд сургалт болон тодорхой ажлуудыг зохион байгуулна гэдэг бага ангийн  багш нарын мэдээлэл боловсруулах, хүргэх, харилцааны сэтгэлзүйд суралцах нөхцөл боломжийг алхам алхамаар бүрдүүлэх юм.







- Багш эцэг эх асран хамгаалагчдын дунд зохион байгуулж явуулах ажлын нөхцөл боломжийг бүрдүүлэх хөрөнгө оруулалтыг хийх УИХ-н гишүүдэд, дотоод боломж, ЗАН-д компьютер, принтер 2-3 багшийн дунд, зөөврийн компьютер нийлүүлсэн



# Үр дүн, дүгнэлт

- Сургуулийн түвшинд багш хөгжих  таатай орчинг тодорхой хэмжээгээр бүрдүүлж ажиллаж байна.
- Багшийн эрх зүйн орчины хүрээнд хууль эрх зүйн мэдлэг мэдээллийг хүртээмжтэй гүйцэтгэж, багшлах эрх, мэргэжлийн зэрэг авах зэрэг үйл ажиллагааны явцад эрх зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллаж байна.
- Багш хөгжих материаллаг орчинг бүрдүүлэхдээ бодит ажлуудыг хийж гүйцэтгэн орчин бүрдүүлсэн. Жишээ нь 2 багшийн дунд 1 нөөтбүүктэй болгосон.

- Багш хөгжих үйлийн орчинг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр мэдлэг боловсролоо дээшлүүлэх бүрэн боломжийг бүрдүүлсэн.
- Багшийн хөгжилд тэднийг дэмжих дэмжлэг хамгаас чухал учраас хичээлийн зохицуулалтыг зөв оновчтой хийх, хичээлээс бусад ажлаас чөлөөлөх, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх
- Багшийг бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд хамт олны дунд мэдээлэх, урамшуулах, амжилт хүсэх зэрэг хэлбэрийн ажлуудыг зохион явуулдаг.
- Багш суралцаж хөгжихөд  сэтгэл  санааны тайван орчин бүрдүүлэхэд хамт олон дэмжлэг болж ажилладаг

- Бидний судалгааны үр дүнгээс харахад МУБИС-ийн Багшийн сургуульд боловсролын зэрэг ахиулах сургалтанд хамрагдаж байгаа багш нар, Модуль 1,2,3 сургалтанд хамрагдаж байсан 8 багшийн бодит жишээ нь сургуулиас багш нарыг дэмжих, багш нар бие биендээ нөлөөлөх, өөрөө бие даан суралцах зэрэгт үр дүнтэй нөлөөлж, ингэснээр багшийн хөгжилд сургууль хамт олны нөлөөлөл шинэ шатанд гарч хамт олны сэтгэл зүйн уур амьсгал мэдэгдэм өөрчлөгдөж байдаг юм.

Анхаарал тавьсанд баярлалаа!

Багш шавийн барилдлага улам бэхжих болтугай.